

Иргэншлийн тухай С.Хантингтоны үзэл баримтлал

Доктор Г.Эрдэнэбаяр.Магистр Г.Ичинноров

Орчин үед иргэншил хоорондын тэмцэл зөрчил улам ширүүн өрнөж буйн нэг тодорхой жишээ нь 2001.09-11-ний үйл явдал мөн. Тэгэхээр иргэншил, түүний мөн чанар, иргэншил хоорондын харилцан хамаарал, универсал иргэншил байх бололцоотой эсэх, орчин үежих буюу модернизацийн асуудал, иргэншил хоорондын мөргөлдөөн, түүний шалтгаан, хэлбэрүүд,иргэншлийн ирээдүйн талаархи илүү тодорхой ойлголтыг С.Хантингтон тодорхой баримтуудаар үндэслэн тайлбарласан юм.Өнөө үед манай дэлхий дэх янз бүрийн иргэншлүүд харилцан бие биенийгээ үгүйсгэх, эсвэл зарим нь бусдыгаа өөртөө уусгах бололцоогүй бөгөөд дэлхий нийтээрээ улс төрийн хөгжлийн шинэ шатанд орсон хэмээх үзлийг тэрээр дэвшүүлсэн байна.

Орчин үед иргэншил хэмээх нэр томъёог философи, улс төр, социологид дараах олон утгаар хэрэглэж байна.¹⁰² Үүнд:

Нэгдүгээрт, Иргэншил бол нийгэм юм гэж үзэх хандлага байна. Өөрөөр хэлбэл, иргэншил нь нийгмийн амьдралын үйл явц,нийгмийн оршин тогтнол,хөгжлийн хэлбэр юм.

Хоёрдугаарт, Иргэншил бол хот, хотжилт бүхий нийгэм гэсэн утгаар хэрэглэж байна. Жишээ нь: Америкийн эрдэмтэн Д.Уилкинсоны хувьд “иргэншил бол арван мянгаас доошгүй хүн ам бүхий хотжилт төлөвшсөн нийгэм” гэсэн утгаар хэрэглэсэн байна¹⁰³.

Гуравдугаарт, Иргэншил бол нийгмийн байгуулал бүхий сонгодог хэлбэр, ялангуяа өрнийн улс гүрнүүдийг багтаан үзэж, технологийн өндөр түвшинд хүрсэн тэдгээр улсуудыг иргэншсэн хэмээн үзэх хандлага юм.

Дөрөвдүгээрт, Иргэншил бол сайн зохион байгуулалт бүхий хүмүүнлэг нийгэм юм “гэж үзэх өөр нэг хандлага байна.

Тавдугаарт, Хүний ухамсартай үйл ажиллагааны үр дүнд иргэншил буй болно гэж үзэх үзэл гарч ирж байна. Энэ нь хүний аж төрөх хэв маягтай холбон иргэншлийг тайлбарлаж буй үзэл юм.

Зургадугаарт, Дэлхий дахинд өөрийн оюуны хүчин чадлаараа гарч ирж бусдад хүчтэй нөлөө үзүүлж буй улс үндэстнийг иргэншилтэй холбон улмаар шашинтай холбож үзэх хандлага байна. Эндээс үзэхэд иргэншлийн тухай ойлголт онолын түвшинд нэгдмэл цэгцтэй болж хараахан чадаагүй гэж хэлж болох үндэстэй юм.

Түүний үзлээр, “Хүн төрөлхтөний түүх бол өөрөө иргэншлийн түүх билээ”¹⁰⁴. Хүн төрөлхтөний хөгжлийг өөр өөр утгаар ойлгох боломжгүй. Иргэншил бол нийгмийн амьдарлын үйл явц, нийгэм түүхтэй хамт үүсэн хөгжиж иржээ. Тэрээр иргэншил судлалд ихээхэн хувь нэмэр оруулсан судлаачид болох О.Шпенглер, А.Тойнби, П.А.Сорокин, К.Квигли, К.Дэвсон, Ф.Браудэл нарын олон бүтээлүүдийг өөрийн судалгаанд өргөн ашигласан байна.Ф.Браудэлийн хувьд “иргэншил гэдэг нь юуны өмнө соёлын орон зай, оршин байх ахуй, соёлын шинж тэмдэг үзэгдлүүдийн цогц” юм. Харин К.Дэвсоны хувьд бол, “иргэншил гэдэг нь “тодорхой ард түмний бий болгосон

¹⁰² Г.Эрдэнэбаяр.Нийгэм ба соёл,иргэншил.УБ.,2004. 44 дэх тал

¹⁰³ Wilkinson D.Spatio-Temporal Boundaries of African Civilizations Reconsidered Comparative Civilizations. Review. 1993. 52-53 p.

¹⁰⁴ Хантингтон.С. “Иргэншил хоорондын мөргөлдөөн, Шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам”. УБ.,2005 23 дахь тал

нэгэн онцгой, өвөрмөц соёлын бүрдлийн үйл явц, түүний дүн”¹⁰⁵ гэжээ. О.Шпенглер иргэншлийг “соёлын зайлшгүй хувь заяа” гээд, “иргэншлүүд нь зөвхөн дээд төрлийн хүмүүс хүрч чадах хийсвэр орчин. Тэдгээр нь бүрэн шийдэл болдгийн хувьд бүрэлдэх явцдаа байгаа аливаа үзэгдэлд удирдамж болдог”¹⁰⁶ гэжээ. А.Тойнбигийн хэлснээр, иргэншлүүд нь “бусдыг өөртөө нэгтгэхээс бус, бусдад уусна гэж байхгүй”. Иргэншил гэдэг бол “бүхэлдээ цогц” юм гэж үзжээ.

Тэгвэл С. Хантингтоны үзлээр, иргэншил гэж юу вэ?, Иргэншлийн мөн чанар юугаар тодорхойлогддог вэ? Түүний үзлээр, иргэншил бол иж бүрдэл цогц ойлголт юм. Иргэншил бол өөрөө соёлын хамгийн том нэгдэл юм. “Иргэншил бол улс төрийн бус, соёлын хэмжүүртэй”¹⁰⁶ үзэгдэл болохыг онцолжээ. Тэрээр, иргэншил нь төрийг бэхжүүлэх, шударга ёс тогтоох, татвар хураах, дайн хийх, гэрээ хэлэлцээр байгуулах зэрэг засгийн газрын үйл ажиллагаанаас үл хамаарна гэж үзжээ. Энэ бол иргэншлийн мөн чанарын талаар талаарх мөн өмнөх үеийн судлаачдаас ялгарах нэг онцлог мөн.

Түүний үзлээр, иргэншлийн мөн чанарыг тодорхойлогч гол шинж нь соёл бөгөөд тэрээр хүн төрөлхтөний түүхэн дэх иргэншлийн хэв маягийн талаар орчин үеийн гол иргэншлүүдийг авч үзжээ. Үүнд: **Синик буюу Хятадын иргэншил, Японы иргэншил, Хиндү иргэншил, Лалын иргэншил Ортодокс / Оросын / иргэншил, Өрнийн иргэншил, Латин Америкийн иргэншил, Африкийн иргэншил** эдгээр болно.

Иргэншлийн ангилал хийхдээ гол шалгуур нь эдийн засаг, улс төртэй холбоогүй гээд, тийм гол шалгуур нь хэл, шашин, түүх, зан үйл, институци, ижил төстэй байдал хэмээн С.Хантингтон тайлбарласан юм. Иргэншлийн тухай түүний онолын хамгийн их шүүмжлэлд өртсөн, сул боловсрогдсон зүйл нь иргэншлийн ангилалын асуудал болно. Ялангуяа Оросын иргэншил, Японы иргэншил, Латин Америкийн иргэншил биеэ даасан голлох иргэншил байж чадахгүй гэсэн шүүмжлэлүүд нилээд их байдаг.

Иргэншлүүдийн хоорондын харилцан хамаарлын асуудлыг С.Хантингтон судалж, үзээд дараах гурван үе шатанд хувааж, тус бүрийн онцлогыг тайлбарлажээ. Үүнд: *Нэгдүгээрт*, Манай эриний 1500-оноос өмнөх иргэншлүүдийн харилцаа (XV зуунаас өмнөх үе орно). Эхний үе шатны хувьд тэд өөр хоорондоо ерөнхийдөө харилцаагүй юмуу, эсвэл хааяа нэг харилцаж байсан онцлогтой. Учир нь тэр үед иргэншлүүд нь орон зай, цаг хугацааны хувьд бие биеэсээ хол оршиж байжээ. Мөн иргэншлүүд нь газар зүйн хувьд ч салангид оршиж иржээ. *Хоёрдугаарт*, Энэ үе бол иргэншлийн хөгжлийн түүхэнд Өрнийн буюу Европын иргэншил сэргэн мандаж эхэлсэн үе (XV-XX зуун хүртэлх 400 жил) юм. С.Хантингтон тэмдэглэхдээ: “Ийнхүү 400 жил иргэншлүүдийн харилцааг өрнийн иргэншлийн нөлөө тодорхойлж байв. Өрнийхний энэ хүчирхэгжлийн шалтгаан бол түүний нийгмийн бүтэц, ангийн харилцаа, хотжилт, худалдааны хөгжил, ертөнцийг үзэх үзэл, үндэсний ухамсар сэргэсэн болон төр-хаан, төр-шашныг тусгаарласан, бюрократ тогтолцоотой холбоотой. Гэхдээ үүний цаана технологийн бусад шалтгаан бий. Энэ бодит үнэнийг өрнийхөн өөрсдөө байнга мартдаг бол өрнийн бус улс түмнүүд хэзээ мартаагүй”¹⁰⁷ гэжээ. *Гуравдугаарт*, орчин үе бол олон иргэншилүүдийн харилцан шүтэлцлийн үе (XX зуунаас эдүгээ хүртэл) мөн. С.Хантингтоны үзлээр, “XX зуунд иргэншил хоорондын харилцаа нь нэг иргэншлийн ноёрхолын үеэс илүү эрчимтэй, тогтвортой, олон талт үедээ шилжин орсон. Өнөө үед өрнийн иргэншил давамгайлсан олон улсын харилцааны системийг давж, олон

¹⁰⁵ 25 дахь тал

¹⁰⁶ Мөн тэнд 28 дахь тал

¹⁰⁷ Хантингтон.С “Иргэншил хоорондын мөргөлдөөн, Шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам” УБ.,2005 36 дахь тал

иргэншилт олон туйлт системийг бүрдүүлж байна. Тэрээр энэ үеийн онцлогийг дараах зүйлстэй холбон тайлбарлажээ. Үүнд: XX зууны улс төрийн лут үзэл суртал болох либерализм, социализм, анархизм, марксизм, коммунизм, социал демократ, консерватизм, национализм, фашизм, христосын ардчилал зэрэг нь бүгд өрнийн бүтээгдэхүүн гэдгийнхээ хувьд нэгдмэл юм. Өөр ямарч иргэншил улс төрийн ийм үзэл суртлыг бий болгоогүй. Улс төрийн нөлөөний төлөөх өрнийн иргэншлийн дотоод зөрчил нь явсаар соёл, шашны нөлөө тогтоохын төлөө иргэншил хоорондын мөргөлдөөнөөр солигдов. Эдүгээ олон туйлт, олон иргэншилт тогтолцоо төлөвших явцдаа байна. Өөр нэг онцлог бол иргэншил хоорондын харилцааны гуравдахь үе бол өмнөх үетэйгээ харьцуулахад эрс идэвхитэй, харин хоёр дахь үеэсээ илүү тэгш эрхтэй, харилцан идэвхитэй үе юм..

XX зууны төгсгөл үед өрнийн (Европын) иргэншил бол дэлхийн хамгийн төгс, универсал мөн гэсэн номлол нэлээд тархсан билээ. Тийм төгс, универсал нийтлэг иргэншил байх бололцоотой юу? Мөн орчин үежих гэдгийг өрнөжих гэж ойлгож болох уу? зэрэг олон асуудлыг С.Хантингтон судалж, шинэ агуулгаар тайлбарласан юм. Энэ талаар С.Хантингтон хэлэхдээ: “Ойрхи Дорнодод мянга мянган залуус жинсээр гангарч, кока кола залгиж байгаа ч Меккад мөргөх, Америкийн иргэний нисэх онгоц дэлбэлэхээ чухам хүн болсны гавъяа гэж үзэж байгаа. Биеэ тоосон ихэрхүү, гэнэн араншингаасаа болж өрнийнхөн өөрийнх нь бараа бүтээгдэхүүнийг хэрэглэснээр өрнийн бус иргэншлүүд аяндаа “өрнөжнө” гэж итгэдэг үзэл юм. Хэрэв тэд өөрсдийн иргэншлээ хийжүүлсэн ундаа, цайрсан өмдтэй зүйрлэсээр байвал дэлхий өрнийн иргэншлээр ямар ойлголт авах болж байна аа? Мэдээлэл, харилцааны глобал сүлжээ бол өнөөгийн дэлхийд өрнийнхөн нөлөөгөө тогтоох гол хэрэгсэл болчихоод байна. Өрнийнхний ноёлсон мэдээллийн глобал сүлжээ цэцэглэхийн хирээр өрнийнхнийг үгүйсгэх нь хандлага ч бас нэмэгдэж байна”¹⁰⁸ гэжээ.

Цааш нь С.Хантингтон универсаль иргэншил байх бололцоогүй гэдгийг дараах байдлаар тайлбарлажээ. Аливаа соёлын гол чухал элемент бол хэл, мөн шашин билээ. Хэрэв шинээр универсал иргэншил бий болж байгаа бол тэр утгаар универсал хэл, универсал шашин дагалдан бий болох ёстой. Бодит байдал дээр ялангуяа хэлний хувьд энэ шаардлага илүү тавигддаг. Энэ бол дэлхийн хүн амын дотор англи хэлээр ярилцагчдын хувь хэмжээ өсч байгаа гэдгээр ойлгогдохоор байна. Түүний үзлээр, “гэвч үүнийг батлах боломжгүй. Харин ч бүр эсрэгээр энэ утгаараа англи хэл бол дэлхийн иргэншлүүдийн хоорондын харилцааны хэрэгсэл болж, Японы банкир, Индонезийн бизнесмен хоёр хоорондоо англиар ярьж байгаа нь тэдний аль нэг, эсвэл хоёулаа англичлагдсан, эсвэл өрнөжсөн гэсэн үг биш”¹⁰⁹ юм. Түүнчлэн дэлхийд эрх мэдлээ тогтоосон тэр гүрний төрөлх хэл нь дэлхийн түгээмэл хэл болмогц тэр ард түмэн ихээхэн бардам болж, бусад ард түмэн тэдний хэлийг сурахаар хошуурдаг. Орчин үед Японы эдийн засгийн хүчин чадал япон бус улс түмэнд япон хэлийг сурахыг тулгаж, Хятадын эдийн засгийн эрчтэй хөгжил хятад хэлийг мөн тийм хэмжээнд гаргаж иржээ. Ялангуяа Хонконгт хятад хэл нь англи хэлийг шахааж, Зүүн өмнөд Ази дахь хятад цагаачдаар дамжин тус бүс нутагт олон улсын бизнес хятад хэлээр явагдаж байна. Өрнийнхний эрх мэдэл, хүч чадал суларч бусад иргэншилд байраа тавихын хирээр бусад нийгэмд ч англи болон өрнийн бусад хэлийг улам бүр бага хэрэглэх боллоо. .

Түүнчлэн тэрээр “универсаль иргэншил”-ийн тухай үзэл баримтлал бол цэвэр өрнийн иргэншлийн хүрээний ойлголт гэж үздэг. Харин XX зууны төгсгөл дэх универсал иргэншлийн номлол бол өрнийнхний соёлын давуу байдлыг хадгалж үлдэх, бусад улс орнуудад өрнийн институцийг даган дуурайх шаардлагатайг илрүүлэхэд чиглэж байна. “Ингэж универсал болгох санаа нь

¹⁰⁸ Хантингтон.С. “Иргэншил хоорондын мөргөлдөөн, Шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам”. УБ.,2005 .46 дахь тал

¹⁰⁹ Мөн тэнд 47 дахь тал

чухамдаа өрнийнхөн өрнийн бус бусад соёлтой сөргөлдөхөөс зайлсхийсэн хэлбэр мөн. Универсал иргэншлийн үзэл санаа бол бусад иргэншлээс дэмжлэг илэрхийлэх хэлбэр бөгөөд тэрхүү санааг нь бусад иргэншлийн хүрээнд тэр бүр дэмжихгүй нь илт байна"¹¹⁰. Хантингтон хэмээн тэрээр үзжээ.

Орчин үеийн нийгэм дэх хүмүүсийн үзэл бодол, үнэт зүйлс, эрдэм мэдлэг, соёл нь уламжлалт нийгмийнхээс эрс ялгаатай. Модернизацийг анх хийсэн иргэншил бол өрнө бөгөөд тэр утгаар ч орчин үед соёлын шинэчлэл өрнөдөд давуу хийгдэж байна. Уламжлалт нийгмүүдийг бодвол орчин үеийн нийгмүүд харьцангуй ижил төстэй болж байгаа нь хоёр шалтгаантай. Нэгд, орчин үеийн нийгмүүдийн өнөөгийн идэвхитэй харилцаа нь нийтлэг соёл бий болгохгүй байж болох авч техник, ололт амжилт, нээлт, практик дадал харилцан шилжих явдлыг хөнгөвчилж, энэ нь уламжлалт ертөнцөд байгаагүй хурдтай тархаж байна. Хоёрт, уламжлалт нийгэм нь хөдөө аж ахуй дээр суурилж байсан бол орчин үеийн нийгэм нь гар урлал, сонгодог хүнд үйлдвэрлэлийг дамжин шинжлэх ухаан, мэдлэгт суурилсан үйлдвэрлэл рүү шилжээд байна.

Дэлхийд цорын ганц, өрнийн загвар руу орчин үеийн аливаа нийгэм ойртох ёстой бөгөөд орчин үеийн иргэншил бол өрнийнх, өрнийн иргэншил бол орчин үеийн мөн гэж дээрхи үзлийг номлогчид нотолдог. Гэвч энэ нь үндсээрээ буруу ойлголт юм. С.Хантингтоны хэлсэнчлэн, орчин үежих гэдэг бол өрнөжих гэсэн үг биш, шинэчлэл хурдаа авахын хэрээр өрнөжих үйл явц сулрах ба уламжлалт үндэсний соёлоо дээдлэх хандлага тэргүүлж эхэллээ.Цаашид хөгжих тусмаа өрнийн ба өрнийн бус нийгмийн иргэншлийн хүчний харьцаанд өөрчлөлт гарч, өрнийн бус орнуудын өөртөө итгэх итгэл сэргэж, үндэс угсаа уугуул соёлоо улам бүр илтгэх болжээ..

Энэ утгаар өөрчлөлтийн үед өрнөжих явц нь шинэчлэлтийг хөхүүлэн дэмжиж, дараа нь шинэчлэл нь өрнөжихөөс татгалзах, хандлагыг бий болгож, үндэсний соёл хоёр хэлбэрээр сэргэж байна. Нийгмийн түвшинд эдийн засаг, цэрэг, улс төрийн бие даасан нэгдмэл байдлыг сэргээж, хүмүүс төрөлх соёлдоо итгэж, соёлоо хайрлан хамгаалах сэтгэлгээ бий болдог. Тухайлбал, Хятад энэтхэгээс буддизмыг авсан, гэхдээ хятадууд "энэтхэгжээгүй" гэдгийг түүх нотолдог. Тэд буддизмыг өөрийн эрэлт шаардлагад нийцүүлж чадсан. Ингэж хятадын иргэншлээ хадгалж үлдсэн түүхтэй. Хятадууд өнөө хэр өрнийнхний христжүүлэх идэвхитэй оролдлогыг няцаасаар ирсэн. Хэрэв хэзээ нэг цагт христосыг авлаа гэхэд, тэд ямар нэг хэлбэрээр уусган авч, иргэншлийнхээ цөм, үнэт зүйлсээ хадгалж үлдэх нь гарцаагүй.

Өөр нэг зүйл бол шинэчлэл хийхийн тулд тэд заавал өрнөжих ёстой гэдэг санаа тэгтлээ итгэл төрүүлдэггүй. Үндэсний уугуул соёл нь нийгмийн шинэчлэл хийхэд гол саад болно, иймээс зөвхөн өрнөжсөнөөр л хүсэн хүлээсэн шинэчлэлээ хийх боломжтой хэмээн үзэх нь буруу ойлголт юм.Өрнийн бус нийгэм өөрийн соёлоо хаяхгүйгээр, өрнийн үнэт зүйлс, институци, практик дадлыг ерөнхийд нь авах замаар шинэчлэгдэх боломжтой, тэгж шинэчлэгдэж ч байгаа улс орон ч цөөнгүй. Өрнөжих нь зарим улсад бүр ч тохиромжгүй байж болно. Энэ талаар Ф.Браудэл "дан ганц иргэншлийг шүтэж, иргэншлийн ялгаа арилахын шалтгаан гэж үзэх нь инээдтэй хэрэг"¹¹¹ юм хэмээн хэлсэн байдаг. Иймд модернизаци гэдэг нь ялгаатай тэдгээр иргэншлийг улам бэхжүүлж, өрнийн нөлөөг харьцангуй сулруулах болно.Түүний үзлээр, хүйтэн дайнд ялсан нь өрнийн иргэншлийн хувьд ялалт бус, харин туйлдад авч ирсэн. Эдийн засгийн бууралт, ажилгүйдэл, төсвийн алдагдал, хөдөлмөрийн зах зээл, ёс суртахууны хямрал, хадгаламжийн хүү буурах гэх мэт асуудал нэмэгдэхийн хамт АНУ зэрэг зарим оронд нийгмийн хагарал, хар тамхи, гэмт хэрэг өссөөр байна.

¹¹⁰ Хантингтон.С "Иргэншил хоорондын мөргөлдөөн, Шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам" УБ.,2005 55 дахь тал

¹¹¹ Braudel. On History, pp. 212-213

Өнөө үед дэлхийн эдийн засгийн эрх мэдэл Зүүн Ази руу шилжиж, түүнийг даган улс төрийн бодлого, цэргийн зэвсгийн хүч тийшээ шилжиж байна. Мөн Энэтхэгийн эдийн засаг сэргэлтийн босгон дээр очиж, лалын ертөнц тэр чигтээ өрнийг дайсагнах боллоо. Өрнийнхний заавар, ёс суртахууны номлолыг бусад үндэстнүүд хүлээн авах явдал улам бүр багасах тусам, өрнийнхний өөртөө итгэх итгэл, ноёрхлоо тогтоох чин эрмэлзэл тэр хэмжээгээр уруудаж байна. Гэвч нэг хэсэгтээ л өрнийнхний ноёрхол хүчтэй, XXI зууны турш хүч, нөлөөллийн хувьд анхдагч нь байсаар байх нь ойлгомжтой юм. Цааш нь, "гэхдээ л иргэншил хоорондын хүчний тэнцвэр өнөөдөр аажмаар өөрчлөгдөж, улам гүнзгийрэх төлөвтэй байна. Ирээдүйд өрнийнхний нөлөө улам бүр суларч, өрнийг шүтэхээ больж, хүч нь алдагдан замхрах шинжтэй боллоо.. Хамгийн их нөлөө бүхий болохоор тийм иргэншил өнөөдөр Азиас түрэн гарч, Хятад нь өрнийн иргэншлийн нөлөөг орлож мэдэхээр тийм хандлага бий болжээ. Иргэншлийн давамгайлал, хүч нөлөө ийнхүү шилжиж байгаатай холбогдон өнөөдөр, магадгүй ойрын ирээдүйд бусад улс орнуудад өөрийн үндэсний соёлыг өрнийнхнөөс дээгүүрт тавьж, үндэсний соёлоо шинэчлэн цааш хөгжүүлэх, улмаар өрнийн соёлоос татгалзах явдал гарч болзошгүй юм"¹¹². хэмээн тэрээр сэрэмжлүүлсэн буй.

С.Хантингтоны үзлээр, өрнийнхний энэ уналт нь дараах шинжийг агуулж байна. Үүнд: *Нэгдүгээрт*, энэ бол аажим явагдах үйл явц. Дэлхийн хэмжээнд өрнийнхөн ноёрхлоо тогтоох хүртлээ 400 жилийг туулсан. Иймээс хүч нөлөөгөө алдах нь мөн тийм хугацааг туулах магадлалтай. "Өрнийнхний уналт одоогоор анхны шатандаа яваа бөгөөд аажим уналт явагдаж, тодорхой нэг цэгт хүрсний дараа эрс хурдтай уналтанд орж болох талтай. *Хоёрдугаарт*, өрнийнхөн хүч нөлөөгөө алдахдаа шулуун шугамаар яваагүй. Энэ нь жигд бус, завсарлагатай, заримдаа сайжирч муужирч, сулрахаа мэдэрмэгц дахин хүчтэй босч ирэх гэх мэт. Ардчилсан, нээлттэй нийгмийн тогтолцоо бүхий өрнийн орнуудад шинэчлэл хийх бололцоо өргөн байна. Гуравдугаарт, өөрийн уугуул соёлоо өрнийнхнөөс хавьгүй дээгүүр гэж Ази, Лалын ертөнцийн аль алин нь илэрхий үзэж байна. Ихэнхи судалгаагаар XXI зуун гараад дэлхийн хамгийн том эдийн засаг нь Хятадынх болохоор байна. Энэхүү эдийн засгийн эрчимтэй хөгжил нь тэдгээр улс орнуудад ашиг орлогоос гадна, өөртөө итгэх итгэлийг авчирсан онцлогтой. Эрх мэдэл, хүч чадал нь ёс суртахуун, соёлын итгэл үнэмшлийн илэрхийлэл байдаг шиг эдийн засгийн хангалуун үзүүлэлт нь мөн тийм илэрхийллийн тусгал юм. Ийнхүү соёлын сэргэлт Азиар түгж байна. Азийн бусад орнуудад өөртөө итгэх итгэл нь сэргэснээр өрнө ба Америкаас орж ирсэн болгоныг дээдлэхээ больжээ.

Зүүн Ази дахь "Азийн соёлын сэргэлт" дараахи агуулгыг өөртөө шингээжээ. Үүнд: *Нэгдүгээрт*, Зүүн Ази дахь эдийн засгийн хөгжлийн хурдтай өсөлтийг өрнийнхтэй харьцуулбал өрнийн бүтээмжийг хэдийнээ даван гарсан бөгөөд үүнээс үүдэн дэлхийн бодлогод хүчний нэгэн шинэ төвийг бүрдүүлнэ гэдэгт азийнхан итгэлтэй байна. "Америкт найтаахад Азид ханиад хүрдэг цаг нэгэнтээ өнгөрсөн" гэж Японы нэгэн сэтгүүлч 1993 онд бичсэн, Малайзийн албаны хүн хэлэхдээ: "Америк өндөр халуунтай байсан ч Азид ханиад тусахгүй" гэж бичжээ. *Хоёрдугаарт*, эдийн засгийн амжилт нь ямар нэг хэмжээгээр Азийн соёлын үр дагавар гэдэгт азийнхан өөрсөддөө итгэлтэй байна. Азийн соёл бол өрнийн соёл, түүний үеэ өнгөрөөж байгаа нийгмийн тогтолцооноос хавьгүй дээр хэмээн тэд үздэг. Азид Күнзийн сургаалийн үнэт зүйлс болох дэг журам, сахилга бат, гэр бүлээ дээдлэх үзэл, хөдөлмөрч зан чанар, хамт олонч үзэл зэрэг нь амжилтын үндэс байсан С.Хантингтон үзжээ. *Гуравдугаарт*, Азийнхан нь өрнийнхнийг бодвол, үнэт зүйлс, эдийн засгийн эрх ашгаа хамгаалах нэгдмэл сонирхолтой байдаг. *Дөрөвдүгээрт*, Азийн хөгжилд хүргэсэн Азийн соёлын үнэт

¹¹² Хантингтон.С. "Иргэншил хоорондын мөргөлдөөн, Шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам". УБ.,2005. 77 дахь тал

зүйлсийг бусад улс орнууд загвар болгох хэрэгтэй гэж Зүүн Азийнхан үзэж байна.

Иргэншлийн тухай С.Хантингтоны онолын нэг үндсэн ойлголт нь "Иргэншил хоорондын мөргөлдөөн" хэмээх ойлголт юм. Ард түмэн хоорондын хэлхээ холбоо, хамтын ажиллагааг соёлын нийтлэг өв нь хөхүүлэн хөгжүүлдэг байтал яагаад соёлын ялгаа нь ан цав, мөргөлдөөнд хүргэдэг вэ? гэдгийг С.Хантингтон дараах зүйлстэй холбон үзжээ. Үүнд: *Нэгдүгээрт*, ерөөсөө хүн гэдэг нь энэ бодгаль цусан төрөл, мэргэжил, соёл, институци, нутаг дэвсгэр, боловсрол, бүлэг, үзэл суртлын зэрэг өөр хоорондоо зөрчилддөг, эсвэл холбогддог олон тооны онцлог, шинжүүдийг өөртөө агуулсан байдаг. Эдүгээ энэ дэлхийн хүн ард соёлын хэмжүүрээр улам их зааглан ялгарах болсноор соёлын бүлэг хоорондын мөргөлдөөнийг улам өсгөжээ. Иргэншил гэдэг бол хамгийн өргөн утгаар соёлын оршин буй бодит байдал бөгөөд энэ утгаар дэлхийн бодлогын төвд өөр өөр иргэншлүүд хоорондын мөргөлдөөн орж ирж байна. *Хоёрдугаарт*, соёлын онцлог, мөн чанараа хүмүүс ихээхэн товойлгож магтан шагшдаг бөгөөд ихэнхдээ хувь хүний түвшинд байр сууриа алдсан, алслагдсан нөхцөлд тийм магтаал илүү чухал болдог. Нийгмийн түвшинд бол өрнийн бус нийгмийн хүч чадал, боломж нь уугуул соёл, түүний мөн мөн чанарыг өөрчлөн шинэчлэхэд түлхдэг. Иймд соёлын онцлог, мөн чанараа товойлгох нь угтаа нийгэм, эдийн засгийн хөгжил, дэвшлийн үр дүн гэж үзэж болно. *Гуравдугаарт*, хувь хүний ба овог аймаг, арьстан, иргэншлийн аль ч түвшинд онцлог, мөн чанараа "бусад" хүний үндэс угсаа, овог аймаг, арьс өнгө, иргэншилтэй харьцуулж гаргаж ирдэг. Түүх нэг иргэншилтэй улс хоорондын харилцаа, өөр өөр иргэншилтэй улс хоорондын харилцааг ямагт зааглаж ялгаж ирсэн байна.

Цааш нь, С.Хантингтон хэлэхдээ "Нэг иргэншлийн "бид", нөгөө иргэншлийн "тэд" хэмээх ойлголт хүн нийгмийн түүхнээ байнга дагалдаастай өнөө хүрсэн бөгөөд дотоод, гадаад эдгээр иргэншлийн мөн чанарын ялгаа нь дараахи хүчин зүйлээс үүдэлтэй" гэж үзжээ. Үүнд: Нэгд, маш өөр гэж үзсэн хүн ардын талаархи таагүй сэтгэгдэл. Хоёрт, тийм хүмүүст үл итгэж, сэрдэж айх болгоомжлол. Гуравт, хэл болон иргэний хэв шинжийн ялгаатай байдлаас шалтгаалан тийм хүмүүстэй харилцахад үүссэн харилцааны хүндрэл. Дөрөвт, бусад ард түмний санаа бодол, хүсэл тэмүүлэл, нийгмийн харилцаа, нийгмийн дадал зуршлыг сайн мэдэхгүйгээс үүдэх бэрхшээл зэрэг болно.

Өнөөгийн дэлхий ертөнцөд тээвэр, харилцаа холбооны салбарт гарсан ахиц дэвшлийн ачаар өөр өөр иргэншилтэй хүн ард өөр хоорондоо илүү нээлттэй, байнга ойр дөт, бас хэвийн харилцаатай болов. Үүний үр дүнд тэдний иргэншлийн онцлог, мөн чанар улам товойн гарч байна. Дэлхий дахинд мөргөлдөөн хаа сайгүй гарч байна. Үүнд буруутан нь чухамдаа хүн өөрөө юм. Өөрийгөө илтгэж, түүнээсээ таашаал авахад нь хүнд дайсан хэрэгтэй. Хүмүүс өөрсдөөсөө ялгаатай болон өөрсдөд нь хохирол учруулж мэдэх хүмүүст үл итгэж, тэднийг аюул занал мэт үздэг. Эдийн засаг нь соёлоо дагана гэдэг нь Зүүн Азийн эдийн засгийн шинэ эвслийн үндсэн үзэл баримтлал байх болно. Түүний үзлээр, "Иргэншил гэдэг нь овог аймаг, үндэстний адил өөрийн гэсэн улс төрийн бүтэцтэй. Иргэншил гэдэгт иргэншлийн нэг соёлтой улс орнууд, мөн өөр иргэншлийн улс орнуудад амьдардаг ижил соёлтой хүн ардыг хамардаг"¹¹³

Түүнчлэн С.Хантингтоны үзлээр, "Өрнийнхний түрэмгий авир, лалынхны үл хүлцэх үзэл болон Хятадын синикийн өөрийгөө дөвийлгөсөн байдлаас ирээдүйн аюултай мөргөлдөөнүүд үүсч болзошгүй юм"¹¹⁴. Иргэншлүүд дотроос өрнийнх нь бусад бүх иргэншил рүү томхон, заримдаа бүр гайтай нөлөө үзүүлж

¹¹³Хантингтон.С. "Иргэншил хоорондын мөргөлдөөн, Шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам". УБ.,2005. 140 дэх тал

¹¹⁴ Мөн тэнд. 197 дахь тал

иржээ. Өрнийнхний хүч чадал, соёл хийгээд бусад иргэншлийн соёл, хүчний хоорондын энэ хэрилцаа бол зонхилох мөн чанар билээ. Бусад иргэншлийн хүч чадал харьцангуй өсөн нэмэгдэхийн хэрээр өрнийн соёлын бусдыг татах хүч суларч, өрнийн бусчууд уугуул соёлдоо улам үнэнч, илүү их итгэлтэй болж ирдэг.

Ерөөсөө өрнө ба бусад нь гэдэг утгаар бол олон улсын харилцааны гол асуудал нь өрнийн, ялангуяа Америкийн соёлыг дэлхийд түгээх гэсэн тэмүүлэл, түүндээ хүч нь багадаж байгаад оршиж байгаа юм. Өрнийнхний ардчилалын үнэлэмж, чөлөөт зах зээл, хязгаарлагдмал засаглал, иргэний индивидуализм, эрх зүйт төрийг өрнийн бус улс орнууд бүх институцидээ нэвтрүүлэх хэрэгтэй гэдэгт өрнийнхөн, ялангуяа АНУ итгэлтэй байна Өрнийнхөн энэ давуу байдлаа хадгалан, өөрийн ашиг сонирхлыг "дэлхийн хамтын нийгэмлэгийн" ашиг сонирхол гэж тодорхойлон хамгаалахыг оролдсоор байгаа бөгөөд цаашдаа ч ингэх болно. Хоёр нүүр, хоёрдмол стандарт, "гэвч үгүй" зэрэг нь универсалист хуурамч төрх байдлынх нь үнэ цэнэ юм. Өрнийнхтэй харьцуулбал, Лал ба Хятад нь соёлын аугаа их уламжлалтай бөгөөд тэдний өөрсдийн нүдээр харвал өөрсдийнх нь соёл өрнийнхөөс хавьгүй дээгүүр байдаг. Иргэншлүүд бол хөгжлийн цаад хэлбэрээрээ хүн нийгмийн гол овог юм. Иймд С.Хантингтоны үзлээр, "Иргэншлүүдийн мөргөлдөөн гэдэг нь глобал түвшин дэх овог аймгуудын мөргөлдөөн юм". Иргэншил хоорондын мөргөлдөөн хоёр хэлбэртэй хэмээн С.Хантингтон үзжээ. Үүнд: Нэгд, Орон нутгийн микро түвшинд хуваагдлын шугамын дагуухи нэг улс доторхи өөр өөр иргэншлийн бүлгүүдийн хоорондын мөргөлдөөн, Хоёрт, Глобал болон макро түвшинд бол өөр өөр иргэншилд харьяалах үндсэн улсууд буюу гол цөм улсуудын хооронд мөргөлдөөн эдгээр болно.

Түүхийн бүхий л үеийн туршид иргэншил хоорондын мөргөлдөөний эх сурвалж янз бүрийн шалтгаантай байв. Гэвч мөргөлдөөнд өөр өөр иргэншилд харьяалах улсууд татагдан орсон бол соёлын тэр ялгаа нь мөргөлдөөнийг улам л дэвэргэнэ. Орчин үеийн иргэншил хоорондын мөргөлдөөнд бие биетэйгээ өрсөлдөх зуураа өөрийгөө тойруулж иргэншлийн нягт хүрээ байгуулахыг зорино. Үүнд, Нэгдүгээрт, орон нутгийн бүлэг хооронд хуваагдлын шугамын дагуу мөргөлдөөн шатлан өргөжөөд тулалдаж байгаа орон нутгийн талуудыг дэмжихээр цөм улсууд оролцсон садан төрлийн бүлэг бүрдэж, нягтарснаар дайтаж болно. Хоёрдугаарт, иргэншлүүдийн хооронд хүчний глобал тэнцвэр өөрчлөгдсөний үр дагавар нь цөм улсуудын дайн байж болно. С.Хантингтоны үзлээр, ХХ зууны төгсгөлд лал ба өрнийн хооронд мөргөлдөөн дахин амилж байгаагийн үндсэн шалтгаан нь эрх мэдэл ба соёл хэмээх суурь асуудалд нь байгаа юм.

Иргэншлийн ирээдүйн тухай асуудалтай холбогдож юуны өмнө дараах асуултууд гарч ирж байна. Үүнд: *Нэгдүгээрт*, өрнийн иргэншил нь өнөөг хүртэл оршиж байсан бусад иргэншлүүдтэй харьцуулашгүй өөр ангилал, өөр төрлийнх үү? *Хоёрдугаарт*, өрнийнхний дэлхий даяарх өргөжин тэлэлт нь бусад иргэншлүүдийн хөгжлийн боломжийг дуусгавар болгож байна уу? гэсэн хоёр асуулт байгаа юм.

Одоо иргэншлүүдийн ирээдүйн талаарх түүний үзлийг авч үзье. "Өнөөдрийг хүртэл өрнийнхний хөгжил түүхнээ үлдсэн бусад бүх иргэншлүүдийн түүхэн хувьсалын үндсэн загвараас тэгтлээ их ялгарахгүй" хэмээн тэрээр тэмдэглэжээ. Тухайлбал, Лалын ертөнц дахин хүчээ авч, Ази эдийн засгийн хувьд эрчимтэй хөгжиж буй нь бусад иргэншил эрүүл саруул, өөдрөг байгааг нотлон харуулснаар үл барам тэд өрнийнхөнд ноцтой аюул учруулж болзошгүйн дохио сануулга мөн. Нэг талаас өрнийнхөн, нөгөө талаас бусад иргэншлийн цөм улсууд оролцсон их дайн үүсгэхгүй нь мэдээж боловч энэ нь огт үүсэх боломжгүй гэсэн үг бас биш юм. Нөгөө талаар өрнийнхний нуралт ХХ зуунаас эхэлж аажмаар, олон жилээр, эсвэл бүр зуунаар үргэлжилж болох юм. Эсвэл өрнө нь өөрийгөө шинэчлэн, дэлхийн үйл хэрэгт нөлөөгөө, дахин тэлж,

хошуучлагч иргэншлийн байр сууриа бэхжүүлж бусад иргэншлийг араасаа дагуулж давамгайлж болно, Энэ талаар С.Хантингтон хэлэхдээ: "Өмнөх иргэншлүүдэд ч ийм алтан үе байсан. Тухайн үедээ үхэшгүй мөнхийн гэж ойлгогдохоор байсан тийм иргэншил бүр эмгэнэлтэйгээр харийнхны халдлагын ялалтаар маш түргэн мөхсөн, эсвэл дотоодын задралаасаа болж аажмаар мөхсөн тохиолдол бий. Ерөөсөө аливаа иргэншлийн үйл явцыг ажихад гадны сүйтгэгч нөлөөллийн эсрэг зогсож чадах тэр чадвар, дотоодын задрал, уналтыг тогтоон барих чадварын аль алин нь шийдвэрлэх, хамгийн чухал хүчин зүйл юм".

Гэвч өрнийнхний ёс суртахууны онолд соёлоо өөрсдөө үгүйсгэж байгаа улс төрийн хагарал зэрэг нь эдийн засаг, хүн ам зүйн асуудлаасаа илүү ноцтой гэдгийг С.Хантингтон онцолсон буй. Ёс суртахууны уналт хэмээн тооцогдох дараах жишээнүүдийг тэрээр авч үзжээ. Үүнд: Гэмт хэрэг, хар тамхины мансуурал, хүчирхийлэл зэрэг нийгмийн эсрэг зан үйл ихсэх, гэр бүл салалт, эцэггүй хүүхэд, өсвөр насны жирэмслэлт, бүрэн бус гэр бүл эцэггүй эсвэл эхгүй зэрэг гэр бүлийн задрал, сайн дурын холбоодод гишүүнээр элсэх нь цөөрч мөн үүнтэй холбоотой хүмүүсийн хоорондын итгэлцэл үгүй болж байгаа АНУ-д дор хаяж буюу "нийгмийн капиталын" ажил, албаны ёс зүйн ерөнхий уналт, хувийн эрх ашгийн хүслээ дээдлэх явдал ихсэх, боловсрох болон оюун санааны хөдөлмөр эрхлэх сонирхол унаж, АНУ-д хичээл сургалтын дүн доод түвшинд очсоныг энд нэрлэжээ. Цаашид өрнийн иргэншил цэцэглэн хөгжих эсэх, бусад нийгмүүдэд нөлөөлөх эсэх нь лалынхан, азийнхны дургүйцэл эсэргүүцлийг дэвэргэж буй ёс суртахууны дээрхи хандлагаа хэрхэн, амжилттай давж гарахаас үлэмж шалтгаалах болж байна хэмээн С.Хантингтон өрнийн иргэншлийн нэгэн сул талыг зүйтэй олж харсан байна.

Цааш нь "Европынхноос ялгаатай нь америкчүүд нэлэнхүйдээ бурханд итгэж, сүм, хийдэд тогтмол очдог, өөрсдийгөө ч шашинтан ард түмэн гэж үздэг. 1980-аад оны дунд үед АНУ-д шашин дахин хүчээ авч байгаагийн илрэл харагдахгүй байсан бол удаахи 10 жилд шашны үйл ажиллагаа үлэмж идэвхжсэн гэхээр байв. Христосын шашны ялзрал өрнийн иргэншлийн амьдрах чадавхид муугаар нөлөөлж болох авч нэлээн удаан хугацааны дараа л тэгэх болов уу" хэмээн үздэг.

Харин АНУ-ын хувьд даруй тулгарах шууд аюултай нэгэн сорилт бий. Америкчуудын түүхэн үндэсний онцлог төрх нь соёлын үүднээс бол өрнийн иргэншлийн уламжлалаар тодорхойлогдож, харин улс төрийн үүднээс бол эрх чөлөө, ардчилал, хувь хүнийг дээдлэх, хуулийн өмнө эрх тэгш байх, үндсэн хуульт тогтолцоог эрхэмлэх, хувийн өмчийг хүндэтгэх зэрэг дээр тогтнодог "америкийн идеал" гэдгээр тодорхойлогддог.

Олон соёлт үзлийг баримтлагчидын гол болгон, АНУ өөрийгөө өрнийн иргэншилд хамаатуулан тодорхойлсоныг эрс шүүмжлэн, Америкт нэгдмэл соёл байхгүй хэмээн үгүйсгэж, арьс өнгө, угсаатны болон бусад үндэсний соёлын дэд бүлгүүдийг онцолдог. Олон соёлт үзлийг баримтлагчид бол "өрнөд дэх гэмт хэргээс өөр бусдыг өрнийнхний өвөөс олж харж чаддаггүй этноцентрист салан тусгаарлагчид мөн"¹¹⁵ гэж Артур М.Шлесинжер хэлжээ. Түүнийхээр бол "америкчуудыг европын нүгэлт өвөөс салгаж, өрнийн бус соёлд автуулах замаар аврах" ёстой юм гэнэ. Олон соёлт хандлага 1960-аад оны үеийн иргэний эрхийн хууль дагасан олон тооны хуулиудад илрэлээ олсон бөгөөд 1990-ээд онд Клинтонь засаг захиргаа олон соёлт нийгмийн үзлийг хөгжүүлэхээ нэг гол зорилгоо болгов.

Өрнийнхний тэр универсализм энх тайванд аюултай, учир нь цөм улсуудын хоорондын томоохон иргэншлийн дайнд хүргэж мэднэ. Тийм дайн нь өрнийнхнийг сүйрүүлж болох учраас өрнийнхөнд аюултай. ЗХУ задарсанаар

¹¹⁵ Arthur M. Schlesinger, Jr. The Disuniting of America: Reflections on a Multicultural Society (New York: W. W. Norton, 1992), pp. 66-67.

өрнийнхөн өөрсдийнх нь иргэншил яриангүй ноёлсон мэтээр төсөөлж байлаа. Өрнийнхөний хувьд хүчний тэнцвэрийг тогтоон барих бус, харин гүехэн газар хөлгөө хэрхэн залахаа тунгааж азгүйтлээ тэвчиж ачаагаа багасгаж соёлоо хамгаалбал энэ нь ухаалаг чиг шугам болох бизээ. Бүх иргэншил үүсэл хөгжил уналтын адил замыг туулдаг. АНУ нь өрнийн хамгийн хүчирхэг гүрэн учраас түүний хувьд энэ үүрэг хамгийн ихээр тохогдоно.

Түүний үзлээр, "Хятад улс өсч өндийн "хүн төрлөхтний түүхэн дэх хамгийн том тоглогч" гэсэн өөрийн итгэлдээ эрдэн XXI зууны эхэн үеийн олон улсын тогтвортой байдалд ноцтой нөлөөлөх болно. Түүхнээ нотолсноор Хятад бол зүүн болон Зүүн Өмнөд Азид Америкийн ашиг сонирхолтой зөрчилдөх хамгийн нөлөө бүхий хүч болон гарч ирээд байна". Эцсийн дүндээ дэлхийн глобал хүч хэдэн зуун дамжин зүүнээс барууншаа нүүдэллэж байснаа дараа нь баруунаасаа зүүн тийшээ шилжиж байсан бол одоо умраас өмнө зүг рүү шилжиж байна. Иргэншлийн энэ дайнаас хамгийн их хожих нь дайнаас гадуур үлдэж чадсан тэр иргэншил л байх болно.

Иргэншлийн ирээдүйтэй холбогдуулан С.Хантингтоны авч үзсэн өөр нэг асуудал нь АНУ болон өрнийнхөни өөрсдийгөө хадгалан үлдье гэвэл өрнийн гэх тэр онцлог төрхөө шинэчлэх явдал мөн. Түүний үзлээр, олон соёлыг хүлээн зөвшөөрөхийг дэлхий дахины аюулгүй байдал шаардаж байна. Аль нэг иргэншлийн универсал онцлогийг дэмжихийн оронд ихэнх иргэншил дэхь соёлын урьдчилсан чухал нөхцөл болох тэр жинхэнэ нийтлэгийг нь олж харах хэрэгтэй. "Универсализмаас татгалзсан олон янзын байдлыг хүлээн зөвшөөрч, нийтлэг үнэт зүйлээ хайх нь олон иргэншилт ертөнцийг бүтээн байгуулах гол шугам мөн" хэмээн С.Хантингтон үзжээ.

Дэлхийн гол шашнууд болох өрнийн христосын шашин, үнэн алдартан, хиндүизм, буддизм, ислам, күнз, даосизм, жүүдийн шашны гол үнэт зүйлс нь нийтлэг учраас ямар нэгэн хэлбэрээр хүн төрлөхтнийг дотор нь ялгаж хуваагаагүй хэмээн олон хүн үздэг. Хүн төрлөхтөн хувьссаар универсал төгс иргэншилтэй болдог юмаа гэхэд тэр нь дээрхи нийтлэг зүйлс дээр суурилагдсан иргэншил байх бололцоотой ажээ. Олон иргэншилт ертөнцөд энх тайвныг хамгаалахын тулд татгалзах хамтын зуучлал зэргээр баяжуулсан гурав дахь дүрэм буюу нийтлэг байдлын дүрмийг хэрэгжүүлэх ёстой. Өөрсдөд нь болон өөр иргэншлийнхэнд нийтлэг тийм институци арга туршлагыг эрж хайх дэлгэрүүлэхийг бүх иргэншлийн хүмүүс хичээх ёстой. Дээрхи зорилтуудыг хэрэгжүүлсэнээр иргэншил хоорондын мөргөлдөөнийг хязгаарлаад зогсохгүй, иргэншлүүдийн иргэншилт байдлыг бэхжүүлэхэд том хувь нэмэр болно хэмээн С.Хантингтон үздэг.

Түүний үзлээр, "Иргэншил гэдэг нь ёс суртахуун, шашин, боловсрол, урлаг, гүн ухаан технологи материаллаг баялаг болон магадгүй бусад олон зүйлийн дээд түвшин дэх хольц нийлэмж юм. Түүхэн хөгжлийн явцад дээрхи бүрдэлүүд заавал нэгэн зэрэг өөрчлөгдөх албагүй. Тухайн иргэншил хувьсан өөрчлөгдөхийн хирээр илүү "суурьшмал" болж, мэдлэг, техникийн дадал нь илүү иргэншсэн болдог Иргэншлийг бүрдүүлэгч элементүүдийн хоорондын өрсөлдөөн сулрах хирээр универсал төр улс төлөвшиж, иргэншил нь хөгжлийнхөө дээд түвшинд буюу "алтан зуунд" очдог. Тэр үед ёс суртахуун урлаг, уран зохиол, гүн ухаан, технологи цэцэглэж, цэрэг, эдийн засаг улс төрийн боломжууд дээд цэгтээ тулдаг

Модернизацийн ачаар дэлхий даяар, ном ёсоороо иргэншлүүдийн материаллаг түвшин дээшилсэн. Гэвч модернизац нь иргэншлүүдийн ёс суртахууны болон соёлын хөгжлийг ахиулсан уу? Зарим тохиолдолд тэгсэн юм шиг байдаг. Бас боолчлол, эрүүдэн тамлах, бие хүнтэй хэрцгий харьцах явдал орчин үеийн ертөнцөд байсаар байна. Энэ үзэгдэл нь өрнийн иргэншил бусаддаа нөлөөлсөний үр дүн үү, тэгвэл өрнийн хүч мөхсөнөөр ёс суртахууны хувьд буцаад хуучиндаа орох уу? 1990 –ээд оны үед олон улсын харилцаанд "жинхэнэ хаосын" зарчим үйлчилж байсныг илтгэх жишээ олон бий. Тухайлбал, дэлхий даяар хууль

ёс дэг журмыг үл хайхран, улс орнууд дампуурч бутран , дэлхийн олонхи хэсэгт анархи байдал газар авч дэлхий даяар гэмт хэрэг үндэстэн дамнасан мафи, хар тамхины наймаа цэцэглэж байна. Хууль ёс дэг журам бол иргэншлийн хамгийн эхний урьдчилсан шалгуур нөхцөл юм.

С.Хантингтон ирээдүйн иргэншлүүдийн талаар хэлэхдээ: “Олон янзын иргэншлүүд энх тайвнаар зэрэгцэн оршиж харилцан суралцаж, нэг нэгнийхээ түүх, урлаг соёлыг судалж мэдрэн, амьдрал ахуйгаа харилцан баяжуулах тийм эрин үе рүү хүн төрөлхтөн явж байна”¹¹⁶ гэжээ. Түүний энэ үзэл санаа бол зөв зүйтэй санаа юм. Энэ талаар Лэстэр Пирсон “Хүн ам нь багтаж ядсан энэхүү бичил ертөнцөд ингэхгүй байх өөр сонголт бол үл ойлголцол зөрчил тэмцэл мөргөлдөөн эцэст нь сүйрлээс өөр юу байх билээ дээ” гэж анхааруулсан байдаг.

“Дэлхийн гол иргэншлүүдийн улс төр, оюун санааны лидерүүдийн өөр хоорондын ойлголцол хамтын ажиллагаанаас манай гаригын болон иргэншлийн ирээдүй шалтгаална” хэмээн С.Хантингтон үзсэн. Иргэншлүүдийн мөргөлдөөнд Европ АНУ хоёр хамт байх ёстой, эсрэг тохиолдолд хоёулаа хамт сөнөх болно. Илүү өргөн хүрээнд том масштаб дээр мөргөлдсөн тохиолдолд “жинхэнэ глобал мөргөлдөөн” нь иргэншил ба варваризмын хооронд болох бөгөөд тэр үед дэлхийн их иргэншлүүд шашин, урлаг, уран зохиол, гүн ухаан, шинжлэх ухаан, технологи, ёс суртахуун, энэрэнгүй ёсны ололт амжилтаараа хүч сэлбэн нэгдэн нягтарч тэмцэх ёстой, эс тэгвэл тэд бүгд хамтдаа сөнөх болно. Ирээдүйд дэлхий дахины энх тайванд учрах хамгийн том аюул занал бол иргэншил хоорондын мөргөлдөөн юм. Дэлхийн дайнаас сэргийлэх хамгийн найдвартай арга зам бол олон улсын шинэ дэг журмыг төлөвшүүлэх явдал гэдгийг С.Хантингтон онцлон үзсэн.

С.Хантингтон иргэншлүүдийн ирээдүйн асуудлыг тусгайлан судалж, дараах чухал санаануудыг дэвшүүлсэн юм. Үүнд: Ирээдүйн ертөнц нь Өрнийн, Күнзийн, Японы зэрэг 7-8 төрлийн иргэншлүүдийн харилцан үйлдлээр тодорхойлогдох болно. Хэрэв дэлхийн III дайн гарах юм бол иргэншлүүдийн хооронд болно. Ирээдүйн иргэншлүүдийн хоорондын зөрчил нь янз бүрийн иргэншлүүдийн хоорондын соёлын зөрчил байх болно. Олон улсын харилцааны гол тэнхлэг нь Өрнийн ба өрнийн бус орнуудын хооронд байх болно гэх зэрэг болно.

Эцэст нь дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд: *Нэгдүгээрт*, С.Хантингтон нь өөрийн өвөрмөц шинэ онолыг боловсруулжээ. Түүний философийн үндсэн ойлголт нь иргэншил юм. Иргэншил ,түүний мөн чанарын тухай С.Хантингтоны үзэл нь өнгөц харахад О.Шпенглер, А.Тойнби нарын үзэлтэй төстэй боловч бас яг адил биш. Эдгээр онолыг харьцуулан үзэхэд төстэй тал нь иргэншил бүр өөр өөрийн онцлогтой, иргэншлийн мөн чанарыг тодорхойлогч гол зүйл нь соёл, ялангуяа шашин гэсэн үзэл баримтлал юм. Харин ялгаатай тал бол С.Хантингтон нь О.Шпенглер, А.Тойнби нарын үзлийг гүнзгийрүүлж, өргөжүүлжээ. Иргэншил бол иж бүрэн ойлголт бөгөөд иргэншлийн мөн чанарыг тодорхойлогч гол шинж нь соёлын нийтлэг, ялангуяа шашин, түүх, хэл, зан заншил, ижил төстэй байдал болдог болдог хэмээн үзжээ.

Хоёрдугаарт, С.Хантингтон нь түүхийн философийн асуудалд анхаарлаа хандуулж, хүн төрөлхтөний түүх бол иргэншлийн түүх гээд, хүн төрөлхтөний иргэншлийн түүхэн хөгжлийг олон баримтанд түшиглэн судалж, иргэншлийн ангилал хийж, орчин үеийн найман гол иргэншлийг онцлон, иргэншил хоорондын харилцааны түүхийг нарийвчлан судалж, тэрхүү түүхийг гурван томоохон үе шатанд хувааж, үе бүрийн онцлогийг тодорхойлжээ.

Гуравдугаарт, С.Хантингтон нь улс төрийн философид “Иргэншил хоорондын мөргөлдөөн” хэмээх шинэ ойлголтыг оруулж, олон туйлт, олон иргэншилт ертөнцийн талаар судалж шинэ үзэл боловсруулсан юм. Түүхээс үзэхэд, иргэншилд сөргөлдөөнтэй, мөргөлдөөнтэй орших нь аюул дагуулдаг тул

¹¹⁶ Lester Pearson. Democracy in World Politics (Princeton University Press. 1955) pp.83-84

орчин үед бие биедээ хүндэтгэлтэй хандаж бие биенийгээ зөвшөөрөх нь чухал гэсэн шинэ санаа дэвшүүлсэн болно.

Энэ бүхнээс үзвэл, өнөө үед иргэншлийн янз бүрийн хэв маягийг аль нэгийг бусдаас нь дээгүүр, эсвэл дорой буурай гэж үзэх боломжгүй. Ямар ч иргэншил өөрийн давуу тал, бас сул талтай байдаг ажээ. Ийм байдал нь тэдгээрийн амьдрал, үйл ажиллагааны нөхцөл, түүх, соёлтой холбоотой юм.

Эцэст нь хэлэхэд, Иргэншлийн тухай С.Хантингтоны үзэл нь үүссэн цагаасаа эхлэн янз бүрийн шүүмжлэлд өртөж ирсэн. Энэ шүүмжлэл нь түүний үзэл баримтлалын зарим сул талыг илрүүлсэн гэж үзэж байна. Тухайлбал, иргэншлийн тухай оновчтой тодорхойлолт өгч чадаагүй, бас иргэншлийн ангилал дээр эргэлзээтэй зүйлс ч бий, Жишээ нь: Оросын буюу ортодоксаль иргэншил бол үнэндээ өрнийн соёлын нийтлэгт хамаарах тул бие даасан голлох иргэншил гэж үзэх нь эргэлзээтэй. Мөн Японы иргэншилд Мейжийн шинэчлэл хүртэл Күнзийн иргэншлийн нөлөө маш хүчтэй байсан бөгөөд Мейжийн шинэчлэлийн үеэс өрнийн иргэншлийн нөлөө хүчтэй байсан зэрэг үндэслэлээр бас гол иргэншил гэж үзэхэд учир дутагдалтай хэмээн үзэж байна.

Ном зүй

- Гуревич.П.С. Соёл судлал. I боть .УБ., 2004
- Соёл иргэншил ба гүн ухаан УБ., ШУА, ФСЭХ, 1998.
- Хавх.Н. Соёл иргэншлийн онол УБ., 2004.
- Хавх.Н. Монголчуудын нүүдлийн соёл иргэншлийн гүн ухаан УБ., 2005.
- Хантингтон.С. Иргэншил хоорондын мөргөлдөөн. Шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам. УБ., 2005.
- Чулуунбаатар.Г. "Нэг улс хоёр иргэншил тогтолцооны хөгжлийн нийгмийн философийн зарим асуудлууд"- Монголын философичдын симпозиум УБ., 1995.
- Чулуунбаатар.Г. XX,XXI зууны зааг үеийн Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил хөгжил УБ., 1999.
- Эрдэнэбаяр.Г. Нийгэм ба соёл, иргэншил УБ., 2004.
- Хантингтон.С. Столкновение цивилизации. "Полис" 1994. №1.
- Цивилизации /сб.ст/ М., 1992.
- Цивилизация и исторический процесс. М., 1983.
- Шпенглер.О. Закат Европы. Т.1, М., 1993.
- Шпенглер.О. Закат Европы. Т.2, М., 1998.
- Ерасов.Б.С. Сравнительное изучение цивилизаций. М., 2003.
- Wilkinson.D.Spatio-Temporal Boundaries of African Civilizations Reconsidered Comparative Civilizations Review. 1993.
- Ougley.C. The Evolution of Civilizations An introduction to Historical Analysis. Indianapolis. 1961.
- Huntington.S. The Clash of Civilizations and the Remaking of the World Order. N.V., 1996.
- <http://www.humanities.edu.ru/db/msg/41216>
- <http://www.iru/biblioarchive/hantington>
- http://www.gumer.info/bibliotek_Buks/History/Eras/index.php
- <http://www.archipelag.ru/geopolitics/stolknovenie/clash2/comment/>